

БҮТЭЭЛ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР ТӨВЛӨРҮҮЛЭХ, ХУВААРИЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Монголын зохиолч, хөгжмийн зохиолч, нийтлэгчдийн нийгэмлэг (цаашид “MOSCAP” гэх)-ийн гишүүдийн зохиогчийн онцгой эрхийг хамгаалж, тэдний үгтэй болон үггүй хөгжмийн бүтээлийг ашигласны төлбөрийг хураан төвлөрүүлэх, хуваарилахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Энэхүү журмыг боловсруулах, батлахдаа “Оюуны өмчийн тухай” хууль, “Зохиогчийн эрхийн тухай” хууль, Оюуны өмчийн газраас баталсан хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд баримтлах журам, MOSCAP-ийн дүрэм, CISAC-ийн Хөгжмийн нийгэмлэгүүдэд зориулсан мэргэжлийн дүрэм болон олон улсын хамтын удирдлагын байгууллагуудтай байгуулсан харилцан төлөөлөх гэрээний нөхцөлтэй уялдуулна.

1.3 Энэхүү журмын зорилго нь хэрэглэгчдээс цуглуулсан лицензийн төлбөрийг шударга, үнэн зөв, зардалд хэмнэлттэй байдлаар хуваарилах аргачлалыг тодорхойлоход оршино.

1.4 Төлбөр хуваарилалтын журмыг Нийгэмлэгийн дүрэмд заасны дагуу Удирдах зөвлөл боловсруулж, MOSCAP-ийн гишүүд уншиж, танилцах үүрэгтэй.

1.5 Нийгэмлэгийн Монгол Улсын нутаг дэвсгэрт хураан цуглуулсан лицензийн төлбөр, харилцан төлөөлөх гэрээтэй гадаадын нийгэмлэгээс хүлээн авсан төлбөрийн хуваарилалтын журмыг батлах хууль ёсны эрх мэдэл, хариуцлага нь Нийгэмлэгийн бүх гишүүдийн чуулганы бүрэн эрхэд хадгалагдана.

1.6 Удирдах зөвлөлөөс гаргасан бүтээл ашиглалтын төлбөрийн хуваарилалтын шийдвэр нь эцсийн бөгөөд хүчинтэй байна. Мөн тухайн төлбөрийг хуваарилсан өдрөөс хойш нэг (1) жилийн дотор нийгэмлэгийн гишүүнээс гаргасан төлбөрийн нэхэмжлэл, маргааны нэхэмжлэлийг Удирдах зөвлөл хүлээн авч хэлэлцэнэ.

1.7 Бүтээл ашиглалтын төлбөрийн хэмжээ тариф, Хуваарилалтын журам нь нийгэмлэгийн албан ёсны цахим хуудсанд ил тод нээлттэй байрлах ба ойлгомжтой хялбар байна.

1.8 Бүх гишүүдийн чуулганаас томилогдсон хяналтын зөвлөл нь төлбөр хуваарилалтын тайланд жил бүр аудит хийж, энэхүү журмын үндсэн зорилго зөрчигдөж байгаа эсэхийг тогтоовол зөрчлийг арилгах, таслан зогсоох зохих арга хэмжээг авна.

1.9 Гишүүн бүр журмын тайлбар, хэрэгжилт, эсхүл 1.8-д заасны дагуу авсан арга хэмжээний талаар хүссэн үедээ асуулт асууж, дахин хянуулах хүсэлт гаргах эрхтэй. Ийм хүсэлтийг тухайн гишүүн гарын үсэг зурсан бичгээр Удирдах зөвлөлд хүргүүлнэ. Удирдах зөвлөл нь үндэслэл бүхий хүсэлтийг боломжит хугацаанд хэлэлцэж шийдвэрлэнэ. Удирдах зөвлөлийн шийдвэр эцсийн байна.

1.10 Энэхүү журмыг дараах хүчин зүйлсээс хамаарч шаардлагатай тохиолдолд өөрчлөн шинэчлэж болно.

- Дата мэдээлэл боловсруулах зардал
- Гишүүдээс ирсэн үндэслэл бүхий санал
- Зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм журмын өөрчлөлт
- Хөгжмийн эрхийг хамгаалах гадаад улсын нийгэмлэгүүдийн харилцан төлөөлөх гэрээний нөхцлүүд
- Шинэ орлогын эх үүсвэр энэ журамд тусгагдаагүй байх нөхцөлд

1.11 Гэнэтийн нэхэмжлэлд зориулагдсан нөөц сан буюу бүтээл ашиглалтын маргааныг шийдэх зорилгоор хадгалах нөөц санд нийгэмлэгийн жилийн нийт орлогын 5 хүртэлх хувийг нөөцөлж, гишүүд маргаантай ашиглалтын төлбөр нэхэмжлэх тохиолдолд лиценз эзэмшигчээс ирүүлсэн ашиглалтын тайлан баримтыг үндэслэн хуваарилна.

ХОЁР. БҮТЭЭЛ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙГ ТӨВЛӨРҮҮЛЭХ ЗАРЧИМ

2.1 MOSCAP-ын санхүүжилтэд дараах эх үүсвэрээс орлого төвлөрүүлнэ:

- Бүтээл ашиглалтын төлбөр буюу лицензийн орлого
- Гадаад хамтын удирдлагын байгууллагын бүтээл ашиглалтаас олсон орлого
- Бүтээл ашиглалтын орлого дээр хуримтлагдсан хүү
- Лиценз эзэмшигчдийн хожуу төлсөн төлбөр дээрх алданги хүү
- Гишүүнчлэлийн жилийн хураамж, шинэ гишүүний элсэлтийн хураамж
- Зохиогчийн эрхийн зөрчлийн төлбөр
- Гадаад, дотоодын байгууллага, иргэдийн хандив, хөрөнгө оруулалт
- Төслийн үйл ажиллагааны орлого
- Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагааны орлого

2.2 Эдгээрээс дараах орлогыг бүтээл ашиглуулсны төлбөр болгон гишүүдэд хуваарилахгүй:

- Зохиогчийн эрхийн зөрчлийн төлбөр (тухайн зохиогч өөрөө авна)
- Хандив, хөрөнгө оруулалт ба тэдгээрийн хүү
- Төслийн үйл ажиллагааны орлого
- Аж ахуйн үйл ажиллагааны орлого
- Гишүүнчлэлийн жилийн хураамж, элсэлтийн хураамж

2.3 MOSCAP гишүүдийнхээ бүтээлийг ашиглуулах лицензийн гэрээнд лицензийн төрөл, олгож байгаа эрх, олгосон эрхийг дахин дамжуулж болох эсэх, бүтээлийг ашиглах хэлбэр, хугацаа, нөхцөл, хамрагдах нутаг дэвсгэрийн хүрээ; бүтээл ашигласны төлбөрийн хэмжээ, төлбөр төлөх нөхцөл, бүтээл ашиглагчийн эрх, үүрэг; гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас хүлээлгэх хариуцлага, маргаан шийдвэрлэх журам заавал тусгаж гэрээний үндсэн дээр бүтээл ашиглуулсны төлбөр цуглуулна.

2.4 Гишүүдийн бүтээл ашиглуулах лицензийн гэрээ байгуулахдаа нийгэмлэгээс баталсан тариф ба гадаад улстай байгуулсан харилцан төлөөлөх гэрээний төлбөрийн нөхцлийг мөрднө.

2.5 Тариф батлагдаагүй тохиолдолд Бүтээл ашигласны төлбөрийн хэмжээг тухайн бүтээлийн шинж чанар, онцлог, ач холбогдол, бүтээлийг ашиглах хэлбэр, хэмжээ, хугацаа зэргээс хамааран ашиглагч талтай хэлэлцэн тогтоосон нэгж үнийн дүнгээр, эсхүл нийт үнийн дүнгээр тодорхойлж болно.

2.6 MOSCAP гишүүдийнхээ бүтээлийг ашиглуулах лицензийн орлогын 25 хүртэлх хувийг үйл ажиллагааны зардалд суутган, үлдсэн 75 хувийг гишүүдэд хуваарилна. Үйл ажиллагааны зардал нь бүтээл ашигласны төлбөр цуглуулах болон хуваарилалтыг гүйцэтгэхэд гарах бүх төрлийн захиргааны болон бусад зардлууд, түүнчлэн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон бусад холбогдох татварын зардлуудыг хамарна. Эдгээр ерөнхий зардалд гишүүнчлэл өргөжүүлэх, зохиогчийн эрхийн удирдлагын дата мэдээллийн санг хөтлөх, лиценз эзэмшигчидтэй хэлэлцээр хийх, лицензийн зөвшөөрөлтэй хөгжмийг ашиглах боломжийг хэрэглэгчдэд бүрдүүлж лиценз олгох зэрэг олон төрлийн үйл ажиллагаанууд багтана.

2.7 Олон нийтийн гүйцэтгэлийн буюу нийтэд тоглуулах, дамжуулах, нэгэн зэрэг дамжуулах лицензийн орлогыг дараах эх үүсвэрээс төвлөрүүлнэ.

- Амьд тоглолт (наадам, тоглолт, шоу, спорт урлагийн тасалбартай болон тасалбаргүй бүх төрлийн энтертайнмент арга хэмжээ)
- Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ (IPTV, олон суваг дамжуулах үйлчилгээ, ТВ, радио, OTT платформ)
- Дижитал дамжуулалт (онлайн караоке, шууд сонсох стриминг, утасны дуудлагын үйлчилгээ, интернетээр дамжуулан аудио эсвэл видео контентыг олон хүнд нэгэн зэрэг шууд дамжуулах эсвэл on-demand түгээх)
- Гадаад орлого (харилцан төлөөлөх гэрээтэй нийгэмлэгээс)
- Бусад дамжуулалт (арын дэвсгэр хөгжим – нийтийн үйлчилгээний газрууд, караоке баар, кино театр, зорчигч тээврийн үйлчилгээ гэх мэт)

2.8 Хуулбарлах эрхийн лицензийн орлого дараах эх үүсвэрээс төвлөрүүлнэ

- Дижитал форматаар апп, платформ, серверт хуулбарлан байнгын ба түр хадгалах
- Оффлайн төхөөрөмж (караоке тоглуулагч, дүрс, дуу авиа тоглуулдаг USB)-д хуулбарлах, олшруулах
- Аудио-видео форматаар CD, пянз, DVD, USB зэрэг биет бүтээгдэхүүн түгээх болон фонограм ба видео контент бүтээх
- Нот, үгийг дижитал ба хэвлэмэл хэлбэрээр нийтлэн түгээх
- Дуут тоглоом, дуут ном, эгшигт хайрцаг ба бусад төхөөрөмжинд хуулбарлах
- Нийтэд түгээх, түрээслүүлэх

2.9 MOSCAP дараах бүтээл ашиглалтын төлбөр цуглуулж, орлого хуваарилахгүй:

- Олон нийтийн өмч болсон бүтээл
- Дуурь, бүжгэн жүжиг, мюзикл, хөгжимт драм зэрэг тайзны бүтээл
- Шашны байгууллагад болсон тоглолт
- Үүсмэл бүтээлийн лиценз

2.10 Гишүүний өөрийн хүсэлтээр дараах лицензийн гэрээг MOSCAP ашиглагч талтай байгуулж болно:

- Синхрон эрхийн лиценз буюу хөгжмийг бүх төрлийн видео бүтээлд ашиглах зөвшөөрөл
- Театрын бүтээлд ашиглах зөвшөөрөл
- Үүсмэл бүтээл бүтээх зөвшөөрөл

ГУРАВ. БҮТЭЭЛ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР ХҮРТЭХ ЭРХ

3.1 Дараах гишүүд нийгэмлэгийн лицензийн орлогоос бүтээл ашиглуулсны төлбөр авна.

- **Зохиогч** хөгжмийн зохиолч, дууны үг ая зохиогч, хөгжмийн найруулагч
- **Хөгжмийн нийтлэгч:** Зохиогч эрхийг хэсэгчлэн шилжүүлж авсан эсвэл уг бүтээл ашиглалтын орлогоос ногдох хувийг авах гэрээтэй хөгжмийн нийтлэгч компани.
- **Өв залгамжлагч:** Нас барсан зохиогчийн эд хөрөнгийн онцгой эрхийг өвлөн авсан хууль ёсны өв залгамжлагч
- **Зохиогчийн онцгой эрх эзэмшигч:** Хөгжмийн бүтээлийг зохиосон хүн (зохиогч) биш, хөгжмийн нийтлэгч биш, өв залгамжлагч биш ч хуулийн хүрээнд худалдан авах, эрх бүрэн шилжүүлэх, хандивлах болон бусад арга замаар зохиогчийн эрх бүхий бүтээлийн зохиогчийн эд хөрөнгийн онцгой эрхийг эзэмшдэг хувь хүн эсвэл байгууллага
- **Харилцан төлөөлөх гэрээтэй гадаад улсын нийгэмлэгүүдийн гишүүд:** зохиогч, өв залгамжлагч, эрх эзэмшигч, хөгжмийн нийтлэгч

3.2 Нас барсан гишүүний бүтээлд ногдох орлогыг 1 жилийн дараа өв залгамжлагч нь авах эрхтэй. Хэрэв гишүүн нас барснаас хойш 3 жилийн дотор өв залгамжлагч нийгэмлэгт гишүүнээр бүртгүүлээгүй бол 3 жилийн хугацаанд ногдсон орлогыг ерөнхий хуваарилалтын санд шилжүүлж бусад гишүүдэд хуваарилна.

3.3 Гишүүнчлэлээ цуцалсан гишүүнд эрх төлөөлүүлэх гэрээгээ дуусгавар болгосноос хойш 6 сар хүртэлх хугацаанд орсон бүтээл ашиглалтын орлогыг үргэлжлүүлэн олгоно.

3.4 Нийгэмлэгийн урын санд гишүүн өөрөө мэдүүлж бүртгүүлсэн, нийтийн хүртээл болсон зохиогчийн эх бүтээлүүд, ардын хөгжмийн шинэ найруулга ба үүсмэл бүтээлд лицензийн орлого хуваарилна.

3.5 MOSCAP нь үүсмэл бүтээл болон шинэчилсэн найруулгын ашиглалтын орлогыг эх бүтээлийн зохиогч ба үүсмэл бүтээлийн эрх эзэмшигчдийн гэрээг үндэслэн хуваарилна. Хэрэв зохиогчийн эрхийн бүтээлийн шинэ найруулга ашиглагдсан боловч, эх бүтээлийн зохиогч эрх эзэмшигчдээс ийм тохиролцоо хийгдсэн тухай мэдэгдэл ирээгүй тохиолдолд MOSCAP найруулагчид бүтээл ашиглалтын орлогоос ногдол хувь оноохгүй.

3.6 Зохиогчид, паблишер, эрх эзэмшигч, өв залгамжлагчид бүтээлд эзэмшиж буй ногдол хувиа MOSCAP-т бичгээр ирүүлсэн нотолгоог үндэслэн хуваарилалт хийнэ. Хэрэв ногдох хувь эзэмшлээ хамтран зохиогчид хоорондоо бичгээр тохиролцоогүй тохиолдолд

- Хөгжмийн үгтэй бүтээлийн үг ая зохиогчдод 50%-50% ногдоно.
- Хөгжмийн үггүй бүтээлийн ногдол хувь эзэмшлийг хөгжмийн зохиолчид 100%

- Ая нь зохиогчийн эрхээр хамгаалагдаагүй хөгжмийн үгтэй бүтээлийн үг зохиогчид 100%
- Пабблишинг редакцтай бол Пабблишер 50% , буюу зохиогчдийн нийт ногдол хувь 50% иас багагүй байна. Пабблишерийн ногдол хувь эзэмшил 50% хэтрэхгүй.

3.7 Зохиогчийн эрхийн хамгаалалтгүй олон нийтийн өмч болсон бүтээлийг /Жнь: ардын уран бүтээл/ шинээр найруулсан тохиолдолд нийгэмлэг нь хөгжмийн найралжуулга хийсэн найруулагчийг зохиогчтой адилтган үзэж Бүтээл ашиглалтын орлого хуваарилна. Зохиогчийн эрхийн бүтээлийн шинээр найруулсан найруулагчид роялти хуваарилахгүй.

3.8 Зохиогчийн эрхийн хамгаалалттай дууны шүлгийг албан ёсны зөвшөөрлөөр орчуулсан тохиолдолд шүлгийн орчуулагчид бүтээл ашиглалтаас ногдол хувь онооно. Энэ хувийг эх шүлгийн зохиогчийн хувиас пропорциональ байдлаар суутгана. Жишээ:

Эх бүтээл	Орчуулагдсан бүтээл
Ая зохиогч – 50%	50%
Шүлгийн зохиогч – 50%	25%
Орчуулагч – 0%	25%

3.9 Хэрэв эх шүлэг нь зохиогчийн эрхийн хамгаалалтгүй бол орчуулсан шүлгийг зохиогчийн эрхийн хамгаалалттай эх шүлэгтэй адил төлбөр ногдуулна.

3.10 Бүтээлийн аль хувилбар нь ашиглагдсан эсэх нь тодорхойгүй эсвэл тогтоох боломжгүй тохиолдолд бүх Бүтээл ашиглалтын орлогыг эх бүтээлийн эрх эзэмшигчдэд хуваарилна. Дэд-шүлэгч, шинээр найруулсан найруулагч нь зөвхөн тухайн албан ёсоор зөвшөөрөгдсөн хувиргалт/найруулга ашиглагдсан нь тогтоогдсон нөхцөлд л Бүтээл ашиглалтын орлого авах эрхтэй.

3.12 Нэхэмжлэлд зориулагдсан нөөц сан буюу бүтээл ашиглалтын маргааныг шийдэх зорилгоор хадгалах нөөц санд жилийн нийт орлогын 5 хүртэлх хувийг нөөцөлж, гишүүд төлбөр нэхэмжлэх тохиолдолд ашиглалтын тайлан баримтыг үндэслэн хуваарилна.

3.13 Лицензийн орлогын түр хадгалалт: Эрх эзэмшигч тодорхойгүй, төлбөр хуваарилахад зайлшгүй шаардлагатай мэдээлэл дутуу орлогыг 2 жилийн дотор эрх эзэмшигчийг тодорхойлсон тохиолдолд эрх эзэмшигчид хуваарилна. Бүтээл ашиглалтын төлбөр нэхэмжилж нөхөн авах хүсэлт ирүүлэхдээ дараах нөхцлийг хангах ёстой.

- Эрх эзэмшигч нь MOSCAP т зохиогчийн эрхээ шилжүүлэх гэрээ байгуулах;
- Эрх эзэмшигч тухайн бүтээлийн эрхийг төлөөлүүлэхээр MOSCAP-ын урын сангийн бүртгэлд бүртгүүлэх.
- Эрх эзэмшигч мөн гэдгээ нотлох
- Хамтран зохиогчийн мэдээллийг MOSCAP т өгөх

Хэрэв 2 жилийн дараа эрх эзэмшигч тодорхой биш хэвээр байвал хадгалсан Бүтээл ашиглалтын орлогыг нэгдсэн хуваарилалтын санд оруулж нийт гишүүдийн тухайн үеийн бүтээл ашиглалтын тайланд үндэслэн хувь тэнцүүлэн гишүүддээ хуваарилна.

ДӨРӨВ.ТӨЛБӨР ХУВААРИЛАЛТЫН ДАВТАМЖ

4.1 Амьд тоглолтын лицензийн төлбөрийг улиралд 1 удаа хуваарилна.

4.2 Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээнд хөгжим ашигласны лицензийн төлбөрийг 1 удаа жилийн эхний улиралд гишүүдэд хуваарилна

4.3 Дижитал хэрэглээний лицензийн орлогыг жилд 2 удаа хуваарилна.

4.4 Нийтийн үйлчилгээний газрын дэвсгэр хөгжим ашигласны лицензийн төлбөрийг жилд 1 удаа хуваарилна.

4.5 Биет бүтээгдхүүнд хуулбарлан түгээх эрхийн лицензийн орлогыг тухай бүрт нь эрх эзэмшигчдэд хуваарилна.

4.6 Гадаадын харилцан төлөөлөх гэрээгээр олсон орлогыг жилд 1 удаа хуваарилна.

4.7 Дээр дурдсан үндсэн хуваарийг үл харгалзан, MOSCAP нь гэрээгээр хүлээсэн үүрэг болон тохиролцсон хугацааг биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай бөгөөд зохистой гэж үзсэн тохиолдол бүрд тогтсон хуваариас гадуур, тухай бүр нь төлөвлөгөөт бус хуваарилалт хийж болно.

4.8 Хуваарилалтыг зардал багатай, үр ашигтай байлгах үүднээс хуваарилалт хийх төлбөрийн доод босго хэмжээг тогтоох бөгөөд энэ нь MOSCAP-ийн зохиогч өв залгамжлагч гишүүдийн хувьд 50,000 төгрөг харин гишүүн байгууллагын хувьд 500,000 төгрөг байна. Хэрэв тухайн хугацаанд төлбөрийн хэмжээ нь эдгээр доод босгонд хүрэхгүй бол төлбөрийг дараагийн хуваарилалтын үед шилжүүлж, хуримтлагдсан дүн нь дээрх хэмжээнээс давсан үед олгоно.

ТАВ. ХУВААРИЛАЛТЫН ТООЦООЛОЛ

5.1 MOSCAP нь Бүтээл ашиглалтын орлогыг лиценз эзэмшигчээс авсан бодит ашиглалтын мэдээлэлд үндэслэн хуваарилна. Хөгжмийн хэрэглээг хянах тоолуурын системтэй, ашигласан бүтээлийн хөтөлбөр гаргах боломжтой лиценз эзэмшигчдээс ирүүлсэн бүтээл ашиглалтын тайлан, дата өгөгдлийг MOSCAP ын урын сангийн бүртгэл ба харилцан төлөөлөх гэрээтэй олон улсын нийгэмлэгүүдийн урын сан болон гуравдагч этгээдүүдийн өгсөн мэдээлэлтэй нэгтгэн, тухайн хөгжмийн бүтээлийн зохиогчийн эрх эзэмшигчийг тогтоож, түүнд ногдох Бүтээл ашиглалтын орлогыг тооцоолно.

5.2 MOSCAP нь 2 үндсэн мэдээлэлд үндэслэн бүтээл ашиглалтын орлогыг хуваарилна.

- Бүтээл ашиглалтын орлого буюу Лицензтэй хэрэглэгчдээс цуглуулсан орлого
- Лицензтэй хэрэглэгчээс ирүүлсэн хөгжмийн бүтээлийн ашиглалтын тайлан

5.3 Бүрэн тооллогод үндэслэх арга (Census)

Нэг хэрэглэгчийн төлсөн төлбөрийг тэр хэрэглэгчийн бодитоор ашигласан, тайлагнасан бүх бүтээлд 100% хуваарилна.

Жишээ нь: Ашиглалт бүртгэх функцтэй дижитал платформууд болон Эфирийн цацалтын бүртгэл хийх боломжтой ТВ радио, амьд тоглолтын хөтөлбөрөөр батлагдсан тасалбарын орлогыг бодит ашиглалтанд үндэслэн хуваарилна.

Дата цуглуулах боловсруулах ажлын өртөг их байх тул энэхүү ашиглалтын бүртгэл тооллогын аргыг нийтийн үйлчилгээний газарт бичлэгээр тоглуулсан арын дэвсгэр хөгжмийн хэрэглээнд ашиглах боломжгүй.

Бүтээл ашиглалтын тайлан гаргах боломжгүй тохиолдолд MOSCAP нь бүтээл ашиглалтын төлбөрийг шударгаар хуваарилахын тулд дараах хуваарилалтын аргачлалыг ашиглана.

5.4 Түүвэрлэх арга (Sample)

Бүрэн тооллогын буюу ашиглалтын тайланд үндэслэн хуваарилалт хийх боломжгүй тохиолдолд, MOSCAP нь тухайн ашиглалтын бодит гүйцэтгэлийг төлөөлөхүйц түүвэр мэдээллийг цуглуулахыг зорьно. Энэхүү арга нь дараах тохиолдолд үр дүнтэй байдаг:

а) хөгжмийн ашиглалт маш их давтамжтай эсвэл ашиглагдсан нийт урын сангийн хүрээ бага байх; болон

б) MOSCAP нь статистикийн ач холбогдол бүхий түүвэр мэдээллийг зардал багатай, үр ашигтайгаар цуглуулах боломжтой байх.

Хөгжмийн ашиглалтын давтамж маш өндөр, мөн тэрхүү их хэмжээний ашиглалтын өгөгдөлд дүн шинжилгээ хийх нь өндөр зардалтай бөгөөд үр ашиггүй байх тохиолдолд түүвэрлэлтийн арга нь хуваарилалтын зохистой бөгөөд практик үндэслэл болдог.

Телевиз, ФМ радиогоор хамгийн их тоглогдсон дууны жагсаалтыг гаргахдаа ТВ радио сувгийн эфирын нэвтрүүлгийг жилд 4 удаа тодорхой хугацааг түүвэрлэн сонгож тайлан гаргасан түүвэр судалгааг үндэслэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний лицензийн орлого хуваарилалтыг хийнэ.

5.5 Адилтгал (Analogies)

Нийтийн үйлчилгээний газрууд Жнь: Худалдааны төв, ресторан зэрэгт тоглогдох арын дэвсгэр хөгжим ашиглалтын төлбөрийн орлогыг шууд сонсгох үйлчилгээний тайлан буюу стриминг сувгуудын хөгжим ашиглалтын мэдээллийг үндэслэл болгож хуваарилна.

Оффлайн төхөөрөмж ашигладаг караоке баарны лицензийн төлбөрийг онлайн караоке платформ аппликейшны ашиглалтын тайланг үндэслэн хуваарилна.

5.6 Хувь тэнцүүлэх арга

Бүрэн тооллого хийх тайлан гаргах боломжгүй лицензийн орлогыг Гишүүдийн бүртгүүлсэн бүтээлийн тоонд үндэслэн нийт лицензийн орлогыг хувь тэнцүүлэн хуваарилж болно.

5.7 (Per Play Basis) Бодит ашиглалт буюу “тоглолтоор тооцох” арга

Тухайн ашиглалтын орлогыг тоглогдсон бүх хөгжмийн бүтээлийн хооронд тэнцүү хуваана.

5.8 Үргэлжлэх хугацаанд суурилсан арга (Duration Basis)

Бүтээл ашиглалтын орлогыг тухайн хугацаанд тоглогдсон хөгжмийн нийт секундээр хувааж, нэг секунд тутмын үнэ цэнийг тодорхойлно. Дараа нь тухайн бүтээлийн нийт тоглогдсон секундийг нэг секундийн үнэтэй үржүүлснээр уг бүтээлд ногдох Бүтээл ашиглалтын орлогыг тооцно.

Жишээ:

“ТВ Суваг1”-ээс тухайн жилд төлсөн нийт цэвэр Бүтээл ашиглалтын төлбөр: **1,500,000₮**

Тухайн хугацаанд “ТВ Суваг 1”-ээр тоглогдсон бүх хөгжмийн нийт секунд: **8,000,000**

Онооны үнэлгээ (нэг секунд тутмын үнэ) = Нийт цэвэр Бүтээл ашиглалтын орлого ÷ Нийт секунд = **₮187**

“Суваг 1”-ээр тухайн хугацаанд “Дуу А” тоглогдсон нийт секунд: **4,000**

“Дуу А”-д ногдох нийт Бүтээл ашиглалтын орлого = Нийт секунд × Онооны үнэлгээ = **750,000₮**

5.9 Ашиглалтын тайлангүй лицензийн орлого хуваарилалт

Технологийн болон системийн хязгаарлагдмал байдлаас болоод тайланд бүртгэгдэж чадаагүй бүтээлийн эдийн засгийн эрхийг хамгаалах үүднээс 2 жилээс дээш хугацаанд нийгэмлэгийн гишүүн болсон гишүүдэд Ашиглалтын тайлангүй лицензийн орлогыг pro rata хувь тэнцүүлэн хуваарилна. Ингэхдээ тухайн жилд уг гишүүний ямар нэгэн бүтээл тоглогдож, бага ч болов төлбөр орж ирсэн бол "идэвхтэй гишүүн" гэж тооцон тайлангүй лицензийн төлбөрөөс олгоно. Харин бүтэн жилийн турш ямар ч бүтээл нь тоглогдоогүй гишүүн ашиглалтын тайлангүй лиценз орлогын хуваарилалтанд хамруулахгүй, дараагийн удаа бүтээл тоглогдож эхлэхэд хуваарилалтанд хамрагдна.

5.10 Гишүүний бус ногдол хувь (Non Member Shares)

Бүтээлийн хамтран зохиогч нь хамтын удирдлагын байгууллагад гишүүнчлэлгүй бол 1 жилийн дотор MOSCAP ийн гишүүн болгохыг зорьно. Хэрэв тухайн эрх эзэмшигчийн бүтээлийн эрхийг Паблишер компани удирддаг бол олгох ёстой хувийг паблишер нийтлэгчид нь төлнө. 2 жилийн хугацаанд холбогдож чадахгүй бол ногдсон орлогыг нийгэмлэгийн гишүүдэд хуваарилна.

5.11 Танигдаагүй ашиглалт гэдэг нь Нийгэмлэгийн бүртгэлд байгаа ямар ч бүтээлтэй тохирохгүй байгаа хөгжмийн ашиглалтыг хэлнэ.

Жишээлбэл, тухайн бүтээлийн бүртгэлийн мэдээлэл дутуу байх, эзэмшигч талууд ямар нэгэн хамтын удирдлагын байгууллагын гишүүн биш байх, бүтээлийн ашиглалтын тайлан

Нийгэмлэгт харахан ирээгүй байх, эсвэл олон нийтийн өмчийн бүтээлийн шинэ, бүртгэгдээгүй найруулга байх зэрэг тохиолдлууд үүнд хамаарна.

Ийм тохиолдолд эрх эзэмшигчийг тодорхойлох боломжгүй тул роялти хуваарилалт хийгдэхгүй бөгөөд тухайн ашиглалтын мэдээлэл нь Нийгэмлэгийн "Тодорхойгүй ашиглалтын мэдээллийн сан"-д хадгалагдана.

Энэ мэдээлэл нь Нийгэмлэгийн гишүүд болон хамтран ажилладаг гадаад дотоодын нийгэмлэгүүд харах боломжтойгоор албан ёсны вэбсайтад 2 жилийн хугацаанд нээлттэй байрлана.

5.12 Хуваарилаагүй ногдол хувь (Undistributed Shares)

Бүтээл ашиглалтын орлогыг хуваарилахад шаардлагатай баримт бичиг дутуу байх орлогыг эрх эзэмшигчдэд хуваарилах боломжгүй тохиолдолд нөөц санд 2 жилийн турш түр хадгална.

Хуваарилаагүй түр хадгалсан бүтээлийн төлбөрийг MOSCAP 6 сар тутам дахин шалгаж, эрх эзэмшигчийг тодорхойлохыг зорьно. Энэ үйл явцад эрх эзэмшигч тодорхойлогдсон тохиолдолд, түгээгээгүй ногдол хувь Бүтээл ашиглалтын орлогыг дараагийн удаагийн хуваарилалтаар олгоно.

Хэрэв 2 жилийн дараа эрх эзэмшигч тодорхой биш хэвээр байвал хадгалсан Бүтээл ашиглалтын орлогыг нэгдсэн хуваарилалтын санд нэмж оруулж нийт гишүүдийн тухайн үеийн бүтээл ашиглалтын тайланд үндэслэн хувь тэнцүүлэн хуваарилна.

5.13 Зохиогчийн эрхийн зөрчил эсвэл өмчлөлийн маргаантай холбоотойгоор тухайн бүтээлд ногдсон орлогыг нөөц сангийн дансанд байршуулна. Тухайн маргааныг шийдвэрлэсэн тухай мэдэгдлийг **MOSCAP**-д бичгээр ирүүлэх хүртэл роялтийн төлбөр нь түр түдгэлзүүлсэн байдалтай хадгалагдана.

5.14. Хэт бага (микро) дүнтэй роялти төлбөрийн мэдээллийг боловсруулж, хуваарилахтай холбоотой гарах зардал нь тухайн хуваарилах роялтийн дүнгээс өөрөө өндөр байдаг. Иймд нэг эрх эзэмшигчид ногдох жилийн нийт төлбөр 5,000 төгрөгөөс доош байвал, уг дүнг 1 жилийн дараа идэвхтэй гишүүдэд хувь тэнцүүлэн хуваарилна.

5.15. Танигдаагүй бүтээл ашиглалт ба эрх эзэмшигч тодорхойгүй 2 жил өнгөрсөн роялти төлбөр болон 5.14-т заасан микро бага дүнтэй роялтийн төлбөрийг нэгтгэн дараах зорилгоор зарцуулж болно: хөгжмийн урлагийг хөгжүүлэхэд чиглэсэн нийгэм, соёлын үйл ажиллагаа явуулах; Нийгэмлэгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх; үйл ажиллагааг сайжруулахад зайлшгүй шаардлагатай зардал гаргах; мөн гишүүдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой зайлшгүй зардал гаргах. Энэ бүх зарцуулалт нь удирдах зөвлөлийн баталсан тухайн санхүүгийн жилийн төсвийн хүрээнд явагдана.

ЗУРГАА. БҮТЭЭЛ АШИГЛАХТАЙ ХОЛБООТОЙ ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА ТООЦОХ

6.1 Удирдах Зөвлөл доторх “Бүтээл ашиглалтын тариф боловсруулах, орлого хуваарилах үйл ажиллагааг хянах хороо” нь бүтээл ашиглалтын тариф төлбөрийн хэмжээ тогтоох, хуваарилалтын бодлого журмыг боловсруулах, хэрэгжүүлэх, жилд 1 удаа эргэн харах, шаардлагатай тохиолдолд шинэчлэх үйл ажиллагааг явуулах үүрэгтэй. Уг хороо нь лицензийн орлогыг хуваарилалт хийхээс 10 хоногийн өмнө бэлтгэсэн хуваарилалтын тайланг хянана.

6.2 Бүтээл ашиглалтын лицензийн орлого ба гишүүдэд хуваарилсан төлбөрийн мэдээллийг хагас, бүтэн жилээр удирдах зөвлөл ба хяналтын хороонд тайлагнаж, аудит хийлгэнэ.

6.3 Бүтээл ашиглалтын тариф, төлбөр хуваарилалтын журам, эрх эзэмшигч нь танигдаагүй бүтээлийн ашиглалтын тайлан, хуваарилаагүй орлогын мэдээлэл гишүүдэд ил тод, нээлттэй, вэбсайтад байрлуулна.

6.4 Нэг буюу хэд хэдэн гишүүн хөгжмийн бүтээлийн эрхийн эзэмшлийн маргаан үүсгэвэл MOSCAP дараах зарчмыг баримтлан маргааныг шийдвэрлэнэ.

Хэрэв шинэ эрх эзэмшигчийн нэхэмжлэл одоогийн эрх эзэмшигчийн нэхэмжлэлтэй зөрчилдсөн тохиолдолд, шинэ эрх эзэмшигч нь өөрийн нэхэмжлэлийг баримтжуулсан нотлох баримт бичгийг ирүүлэх шаардлагатай.

MOSCAP нь тухайн баримт бичиг иртэл одоогийн эрх эзэмшигчдэд Бүтээл ашиглалтын орлогыг төлсөөр байна.

Шинэ нэхэмжлэгчээс баримт бичиг ирсэн тохиолдолд, анхны нэхэмжлэгч нь өөрийн нэхэмжлэлийг баталгаажуулах 30 хоногийн хугацаатай. Энэ хугацаанд тухайн бүтээлийн бүх ашиглалтын орлогыг түр хадгалалтанд байлгана.

Хэрэв анхны нэхэмжлэгч 30 хоногийн дотор хариу өгөөгүй тохиолдолд нэхэмжлэл нь устгагдахыг MOSCAP мэдэгдэнэ. Энэ хугацаанд Бүтээл ашиглалтын орлогыг мөн түр хадгалалтанд байлгана.

Нийгэмлэг зөвхөн маргаанд байгаа ногдол хувийг түр хадгалалтанд байлгана.

Нийгэмлэг нь баримт нотлох бичгийн үнэ цэнийг шүүн тогтоохгүй. Харин баримт бичигт дараах мэдээлэл багтсан эсэхийг шалгана: ашиглах хугацааны хязгаар, нутаг дэвсгэр, тодорхой бүтээл/урын сангийн хязгаарлалтууд, бүх эрх эзэмшигчийн гарын үсэг болон огноо.

Нэхэмжлэл гаргасан гишүүд Хоёулаа баримт бичгээ баталгаажуулж чадсан тохиолдолд, аль нэг нь MOSCAP ийн удирдах зөвлөлөөс тухайн бүтээлийн талаар гомдол **маргаан** хүсэлт гаргах боломжтой.

Бүтээлийн ашиглалтын талаар маргаан үүсгэсэн орсон тохиолдолд, нийгэмлэг нь тухайн бүтээлийг маргаанаас гаргахын тулд шүүхийн шийдвэр эсвэл нэхэмжлэгчдийн хоорондын тохиролцоог шаардана.

